7. Барилга байгууламж, техник, технологи, тоног төхөөрөмж, барилгын материал, зураг төсөл, угсралт, ашиглалтын аюулгүй ажиллагааг сайжруулах замаар нийтийн аюулгүй байдлыг хангуулна.
8. Иргэнийг сурч боловсрох тэгш боломж, чанартай боловсрол эзэмших нөхцөлийг хангуулж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.
9. “Дижитал шилжилт-хэрэглэгчтэй хамтарсан хяналт”-ыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
10. Мэргэжлийн хяналт, аж ахуйн нэгж байгууллага, хэрэглэгчийн хамтын хяналтын тогтолцоог төлөвшүүлэх
11. Үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг удирдах дээд байгууллагуудад болон олон нийтэд тайлагнах, танилцуулах, шуурхай мэдээлэх.
12. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хэрэгжилтийг зохион байгуулах
13. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх
14. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах ажлыг зохион байгуулах
15. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх
16. Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангах
17. Бодлогын баримт бичигт тусгагдсан Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулж, гүйцэтгэл үр дүнг хангуулах
18. Дотоод хяналт шалгалт хийх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын "Дотоод хяналтын ажлын хэсэг"-ийг 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсэг тайлант онд байгууллагын албан хаагчдын цаг, ашиглалт, албан бичиг, өргөдөл гомдлын барагдуулалт лабораторийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, 2021 онд үйлдэгдсэн улсын /ахлах/ байцаагчийн баримт бичиг болох хамтарсан төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж холбогдох хууль стандартын хүрээнд сургалт зохион байгуулж, шалгалт хийсэн

тухай материалууд болон бусад хяналт хийсэн материалууд тандалт судалгаа, хяналт шинжилгээ, баталгаажуулах хяналт улсын /ахлах/ байцаагчдын боловсруулсан удирдамж, танилцуулга, улсын /ахлах/ байцаагчдын шийдвэр /акт, албан шаардлага, дүгнэлт/ баримт бичгийг нэг бүрчлэн үзлэг дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дотоод аудитын алба, аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2.0 хувиар буюу 17,299.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13,839.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 2.0 хувиар буюу 18,621.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 14,897.4 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,057.7 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “Emerald” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 878,599.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 7,026.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 94,748.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн онцгой байдлын комиссоос 2,440.0 мянган төгрөг, ОБГ-с 5,112.0 мянган төгрөг, МХЕГ-с 878.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 988,804.0 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 878,599.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 7,026.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн онцгой байдлын комисс, ОБГ, МХЕГ-с 8,430.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 894,055.6 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Зардал:

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 931,355.6 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 883,555.6 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 873,827.3 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140032001 тоот дансанд 878,599.2 мянган төгрөгийн орлого, 878,599.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140032401 тоот дансанд 8,430.0 мянган төгрөгийн орлого, 8,430.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,159,058.4 мянган төгрөг, тайлант онд аймгийн Засаг даргын нөөц сангаас 52,800 мянган төгрөгөөр автомашин, хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлж үнэ шинэчлэн тогтоосон 33,563.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,990.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй

шилжүүлэн орлого авч, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 49,992.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,603.5 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг данснаас шилжүүлэн хасаж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,202,317.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 67,907.9 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 115,129.7 мянган төгрөг, МХЕГ, ХЦС, аймгийн ОБГ-с үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 4,394.4 мянган төгрөг, нийт 119,524.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 109,732.9 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 77,699.0 мянган төгрөг байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант жилийн авлагын данс эхний үлдэгдэл 0 төгрөг, авлага нэмэгдсэн 7,026.4 мянган төгрөг, хасагдсан 7,026.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 871,427.5 мянган төгрөг, хасагдсан 871,427.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 25 байгууллагатай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 77,699.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 856,242.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	67,907.9	77,699.0	9,791.1
Үндсэн хөрөнгө	808,585.0	856,242.4	47,657.4
Нийт хөрөнгө	876,492.9	933,941.4	57,448.5
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	876,492.9	933,941.4	57,448.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	876,492.9	933,941.4	57,448.5

Бараа материалын дансны үлдэгдэл 77,699.0 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 9,791.1 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын

үлдэгдэлд нэг удаагийн бээлий, маск, хамгаалах хувцас комбинзоны нөөц үүссэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 856,242.4 мянган төгрөг болж 47,657.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аймгийн Засаг даргын нөөцөөс автомашин, урсгал санхүүжилтээс 10,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж / 1 зөөврийн компьютер, 2 суурин компьютер, 5 принтер / худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 53,196.7 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 57,595.4 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 933,941.4 мянган төгрөг болж, 57,448.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 992,005.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 5,000.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээнээс 113,000.0 мянган төгрөг, нийт 1,110,005.3 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөн, бараа ажил үйлчилгээний урсгал зардалд 992,005.3 мянган төгрөг, барилгын их засварт 113,000.0 мянган төгрөг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 127,111.3 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 864,894.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 4,000.0 мянган төгрөг, нийт 868,894.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

МХЕГ-с 2021 оны 7, 12 дугаар саруудад 2 удаа төсөвт тодотгол хийгдэж, улсын төсвөөс санхүүжих эх үүсвэр 878,599.2 мянган төгрөгөөр баталж, батлагдсан төсвийг 13,705.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 878,599.2 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, 865,637.3 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 12,961.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 7,026.4 мянган төгрөгийг МХЕГ-ын дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 865,637.3 мянган төгрөг буюу 98.5 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлгийг байгууллагын веб сайтад болон Facebook хуудсанд нийтэлж байна.

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар зөвлөгөө зөвлөмж бичлэгээр 14, сэрэмжлүүлэг 111, хяналт шалгалтын мэдээ 78, нийт 203 мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээж ажилласан байна. Мөн аймгийн ТBS телевизэд мэргэжлийн байгууллагаас худалдаа үйлчилгээний газруудад тусгай нөхцөл шаардлагыг хангуулах талаар зөвлөгөө мэдээллийг 4 удаа өгч ажилласан байна. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллах талаар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 483 төрийн болон хувийн хэвшлийн ААН, байгууллагуудад иргэдийг маск зүүх, зай барих гараа угаах гэх мэт сэрэмжлүүлэг, зөвлөмж нийт 858 ширхгийг цахим сүлжээ, постер, санамж хуудас хэлбэрээр тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна. Мөн Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, УОК-ын 2021 оны 18 дугаар тушаалаар батлагдсан түр журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 199 объектод тусгай нөхцөл шаардлагыг хангуулан ажиллах талаар улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

МХГ-с 2021 онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 4,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 7,026.4 мянган төгрөг төвлөрүүлж 175.6 хувиар биелүүлсэн байна.

Жамцо ХХК-с 2021 оны 3 дугаар сарын 13-ны өдөр starex маркийн автомашин худалдан авч, аймгийн МХГ-т Засаг даргын нөөц сангаас 52,800.0 мянган төгрөгөөр автомашин худалдан авахыг аймгийн Засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн А/537 дугаар захирамжаар шийдвэр гаргуулсан байна.

Тайлант оны 6 дугаар сар, 12 дугаар саруудад 4 нэр төрлийн 8 ширхэг 10,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авч байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/26 тушаалаар зөвшөөрөл авч, шийдвэрлэсэн байна.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Хөрөнгийн ашиглалтын хугацаа ба үнийг шинэчлэн батлах тухай” 08 тоот албан бичгийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 66 нэр төрлийн 80 ширхэг хөрөнгийн 33,563.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,990.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй шилжүүлэн орлого авч, 49,992.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,603.5 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг данснаас шилжүүлэн хассан байна.

МХЕГ, ХЦС, аймгийн ОБГ-с 4,394.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээж авсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 147 мэдээлэл байршуулж, 2 мэдээлэл хугацаа хоцроож 98,7 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын ажилтнуудад илүү цагийн хөлсийг холбогдох журмыг баримталж хүсэлт бичүүлж, зөвшөөрсөн баримтыг үндэслэн олгох, аливаа санхүүгийн гүйлгээг хүчин төгөлдөр цаасан болон цахим баримтаар баталгаажуулах 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, Сангийн яамнаас төсөвт байгууллагад хөтлөгдөх шаардлагыг хангаж зөвшөөрөгдсөн Нягтлан бодох бүртгэлийн программаар бүртгэлийг хөтлөх 1 зөвлөмж өгснийг хагас хэрэгжүүлж, аймгийн МХГ-ын даргын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн №299 тоот албан бичгээр төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тооллогын ажлын хэсэг байгууллагын даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай хийж, ТӨБЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 27-ны 251-р тогтоолоор МХЕГ-с Төв аймгийн МХГ-т балансаас балансад шилжүүлсэн хөрөнгөнөөс тус бүр 1,518.2 мянган төгрөгийн үнэтэй 2 мотоциль байгууллагад ирээгүй байгааг илрүүлж илтгэх хуудсаар танилцуулсан байна. /Нийт үнэ 3,036.3 мянган төгрөг/ Удирдлагаас энэ талаар аудитор асуулга авахад: "МХЕГ-аас 2 ширхэг мотоциль байгууллагад ирүүлээгүй шууд сумын

байгаль орчны хяналтын улсын байцаагчид шилжүүлсэн байгааг тогтоосон” гэж хариулт өгсөн. Энэ асуудлыг нотлох шаардлагатай тул дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 47,123.4 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 27,831.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 713.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 20,004.7 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангуудын уялдааг шалгахад санхүүгийн байдлын тайланд тавилга эд хогшил түүний элэгдлийн хэмжээг данснаас хасагдсан дүн 7,603.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 20,228.3 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй, нийт 27,831.7 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.3 Албан шаардлага

Сангийн яамны шаардлагыг хангасан, төсөвт байгууллагад хөтлөгдөхөөр зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн программаар бүртгэлийг хөтлөөгүйгээс санхүүгийн тайлан “Иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй алдаатай тайлагнадаг, журналуудын харьцсан дансууд давхар, эсвэл сонгогддоггүй татагддаг, Интерактив Би-Ай ХХК-ны “Emerald” программ ашиглаж байгаа зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өмнөх онд өгснийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх” гэсэн Сангийн яамны шаардлагыг хангаагүй программаар бүртгэлийг хөтөлж байгаа зөрчил байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол албан шаардлага өгөх" гэсний дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 дугаар тогтоолоор актлахаар шийдвэрлэгдсэн 14 нэр төрлийн 15 ширхэг 8,791.7 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж хэрэгжүүлээгүй зөрчил байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.1-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллагын шийдвэрийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлж, хариу тайлагнах

2. Зориулалтын бус зарцуулалттай холбоотой асуудал

1.2. Илрүүлэлт:

Байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/26 тушаалаар зөвшөөрөл гаргаж, 4 нэр төрлийн 8 ширхэг 10,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан байна. Энэ хөрөнгийг худалдан авахдаа үнийн харьцуулалт хийсэн мэдээлэл, материал байхгүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", ТӨБЗГ-ын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журмын 3.3-д "Төрийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох, үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий

байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтална.” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийг худалдан авахдаа үнийн харьцуулалт судалгаа хийж, шийдвэр гаргасан хурлын тэмдэглэл бусад материалыг хавсаргаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Мэргэжлийн хяналтын газар	4	47,123.4	1	27,831.7	0	0.0	1	713.0	2	19,291.7